

МОНГОЛЫН БҮЖГИЙН СПОРТЫН ХОЛБОО

БҮЖГИЙН ХАМТЛАГУУДЫН (ФОРМЕЙШН) ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

1. Тэмцээн явагдах хөтөлбөр

Формейшн тэмцээнүүд нь хоёр төрлөөр явагдана.

2.1. Стандартын бүжгүүд

2.2. Латин-Америкийн бүжгүүд

2. Тэмцээний хувцаслалт

Стандартын хэсэгт: Эрэгтэй хувцас хар эсвэл хар хөх өнгөтэй байх ёстой.

Латин хэсэгт: Эрэгтэй хувцас өнгийн байхыг зөвшөөрнө. Гэхдээ багийн бүх эрчүүд ижил өнгийн хувцастай байх ёстой. Чимэглэлгүй байхыг зөвшөөрнө.

3. Тавилтын үндэс

Стандартын хамтлагуудын тавилт Вальс, Танго, Венийн вальс, Удаан фокстрот, Хурдан фокстротын хөдөлгөөнүүд дээр үндэслэгдэх ба 16 такт хүртэл Латин-Америкийн ямар нэг бүжгийг багтааж болно.

Латин-Америкийн хамтлагуудын тавилт Самба, Ча-ча-ча, Румба, Пасодобль, Жайв болон Латин-Америкийн бусад хөдөлгөөнүүд дээр үндэслэгдэх ба 16 такт хүртэл Стандартын ямар нэг бүжгийг багтааж болно.

5. Гоцлол хэсэг ба үргэлжлэх хугацаа

Стандартын тавилтанд гоцлол хэсэг (эрэгтэй эмэгтэй хаалттай байрлалыг тавьж) нь аль нэг бүжигт 8 тактаар хязгаарлагдах ба бүх тоглолтын туршид 24 тактаас хэтрэх ёсгүй. Энэ нь Латин-Америкийн бүжгүүдэд хамаарахгүй, энд гоцлол нь ердийн хэсэг байна.

6. Өргөлт

Өргөлтийг аль аль төрөлд зөвшөөрөхгүй.

Жич: Өргөлт бол партнерийнхаа дэмжлэг тусламжтайгаар бүжигчний хоёр хөл газраас ижил хугацаагаар өргөгдөх хөдөлгөөн.

7. Хамтлагийн бүрэлдэхүүн

Тэмцээний бүх баг 6 эсвэл 8 хосоос бүрдэнэ. Аливаа бүжигчин нэг тэмцээний туршид нэгээс илүү багт бүжиглэж болохгүй.

8. Сэлгээ

Тэмцээний үед хамтлагийн гишүүд 4 хүртэл солиогоор солигдож болно.

9. Тавилтын үргэлжлэх хугацаа

Формейшн хамтлагийн бүжгийн тавилт нь оролт, гаралтыг багтаагаад 6 минутаас хэтэрч болохгүй. Энхүү 6 минутын 4.5 минутаас багагүй хэсэг нь шүүлтэнд хамаарах ба эхлэл төгсгөл нь ялгарч танигдахаар хэв маягтай байх ёстой.

Хамтлагууд энэхүү заалтыг дагаж мөрдөхгүй тохиолдолд Ерөнхий шүүгч эрхийг нь хасч болно.

10. Шүүгчид

Формейшн тэмцээний туршлагатай шүүгчдийг шилж сонгож авна. Формейшн тэмцээнийг 5, 7, эсвэл 9 шүүгч үйлчилнэ.

Тэмцээний явцад шүүгчид хосын тэмцээн шиг талбайн хажуугаар биш харин үзэгчийн тавцан дээр байрлана. Шүүгчид талбайтай харьцуулахад илүү өндөр байрлалд хамтлагийн тавилтын хөдөлгөөн ба зураглалын зөв, тодорхой байдал, шугамын тэгш жигд байдал ба хамтлагийн жигдрэлт, хөдөлгөөн ба позуудын ижилсэлт (синхронизац), хос тус бүрийн

болон тамирчин тус бүрийн ажиллагааг тоймлон харах боломжоор хангахуйц байрлах ёстой. Тэмцээний зохион байгуулагч нь Ерөнхий шүүгчийн зөвлөснөөр үзэгчдийн тавцангийн тасалбар зарагдаагүй эгнээнд шүүгчдийн хооронд хоёр хоосон суудал байхаар тооцоолж засна.

11. Шүүлтийн дүрэм

Хамтлагуудын үзүүлбэрийг үнэлэхэд хосын тэмцээний нэгэн адил үнэлгээний систем ашиглагдана:

Сонгон шалгаруулах даваанд оноогоор дүгнэнэ (шүүгч Ерөнхий шүүгчийн заасан тооны хамтлагийг харгалзах тэмдэглэгээ хийж дараагийн раундад сонгож авна)

Финалд байр эзлүүлнэ (шүүгч финалд үзүүлбэр хийсэн хамтлаг бүрийг нэгээс дараалуулан байр эзлүүлэн жагсаана)

Үүнд Скейтинг систем ашиглагдана.

Тооллогын комисс шүүгчийн хуудсан дээр хамтлагуудыг бүртгэлийн хуудсан дээрх гаралтын дугаарын дарааллаар байрлуулна.

Үүнтэй холбоотойгоор зохион байгуулагч хамтлагуудыг үзүүлбэрээ хийхээр талбайд гарахынх нь өмнө талбай дээр тухайн хамтлагийн шүүгчийн хуудсан дээр заагдсан дугаарыг томоор хэвлэсэн байдлаар талбайд байрлуулна

Финалд сугалааны дагуу сүүлийн хамтлаг үзүүлбэрээ дууссаны дараа шүүгчид талбай руу бууж, хамтлаг тус бүрийн эзэлсэн байрыг жижиг самбарыг (карт) өргөж үзүүлэх замаар финалын шүүлтийн дүнг танилцуулна.

Тооллогын комисс шүүгчдийн өргөж танилцуулсан байр шүүгчийн хуудсан дээрх байртай тохирч байгаа эсэхийг хянана. Комисс бүх шүүгчдийн хуудсыг боловсруулж дүнгийн хуудас гаргана.

12. Фонограмм буулгах.

Хамтлагуудын тэмцээний явцад хуурцаг эсвэл бусад дуу бичлэгийн фонограмм ашиглагдана. Заал нь өндөр чанарын дуу өсгөгч аппаратаараар тоноглогдсон байх ба зохион байгуулагч орчин үеийн дууны тоног төхөөрөмжийг эзэмшсэн туршлагатай дууны найруулагч ажиллуулна. Хамтлагийн төлөөлөгч өөрийн хамтлагийн фонограммыг урьдаас дууны найруулагчид өгч, прогон болон тэмцээн дээр үзүүлбэр гүйцэтгэх үед түүний хажууд байж, хамтлагийн ахлагчийн талбайгаас илгээсэн дохиог тайлбарлана.

13. Талбайд турших ба тавилтын прогон

Тэмцээн эхлэх хүртэл зохион байгуулагч хамтлаг бүрд талбайд фонограммтай турших, тавилтаа прогондох боломжийг ижил нөхцөлтэйгөөр олгоно.

Зохион байгуулагч тэмцээн дээр талбайн хэлбэр, хэмжээ, тэмдэглэсэн төвийн шугам прогон дээр байсантай адил байх нөхцлийг хангах ёстой. Зохион байгуулагч прогон дээр дууны найруулагч ба тооллогын комиссын төлөөлөгчийг байлцуулна.

Хамтлагуудын талбайд прогон хийхээр гарах дараалал нь бүртгэл-тооллогын комиссын бүртгэлийн хуудсан дээрх гаралтын дугаарын дарааллаар байна. Хамтлаг бүрийн прогонд 15 минутаас багагүй хугацаа хуваарилагдана.

14. Прогон дээр Ерөнхий шүүгчийн үүрэг

Тэмцээний Ерөнхий шүүгч хамтлаг бүрийн прогон дээр байлцаж хамтлаг/хамтлагуудад энэхүү дүрэм зөрчигдөхөөс сэргийлж зөвлөгөө өгнө. Хэрэв тэмцээний үед дүрэм зөрчигдвөл Ерөнхий шүүгч хамтлагийн эрхийг бусад шүүгчидтэй зөвлөж болон зөвлөхгүйгээр хасах эрхтэй.

15. Тэмцээн дээрх тавилт, фонограмм ба хувцаслалт

Тэмцээн дээр прогоны үед Ерөнхий шүүгчид үзүүлсэн тэр фонограмм, тавилтыг гүйцэтгэх ёстой. Тэмцээн дээрх тамирчдын хувцас нь прогоны үед Ерөнхий шүүгчид үзүүлсэн тэр хувцас байх ёстой. Тэмцээний явцад хувцсаа солихыг хориглоно.

Тэмцээний үед хамтлаг үзүүлбэрээ хийж байх үед түүний төлөөлөгч (хоёроос илүүгүй) талбайн урд талд талбайн захад байрлаж болно.

16. Сугалаа

Тэмцээний шат бүрийн өмнө Ерөнхий шүүгч бүртгэл-тооллогын комиссыг байлцуулан хамтлагуудын талбайд үзүүлбэрээ гүйцэтгэхээр гарах дарааллын сугалааг явуулна. Сугалааг үзэгчдийн зааланд явуулах ёстой.

Ерөнхий шүүгч аль нэг хамтлагийн төлөөлөгч ирээгүй тохиолдолд сугалааг эхлүүлэх эрхгүй. Сугалаанд Ерөнхий шүүгчийн гарын үзэг, хамтлагуудын тэмцээн дээрх гаралтын дугаарыг бичсэн жижгэвтэр хуудас цаас ашиглана. Сугалаа явуулах үед хуудсан дээрх бичилтүүд оролцогчдод харагдахааргүй далдлагдсан байх ёстой.

Сугалааны хуудас тухайн шатанд хичнээн хамтлаг оролцохоор бүртгэгдсэн төдий тоотой байх ёстой.

Сугалах дараалал нь бүртгэл-тооллогын комиссын бүртгэлийн хуудсан дээрх дарааллаар явагдана.

17. Раундын тоо

Тэмцээнд 5-аас олон хамтлаг оролцох үед тэмцээн ганц шатнаас тогтож болохгүй

18. Энэхүү дүрмийн эх үүсвэр

Энэхүү дүрмийг Олон улсын бүжгийн спортын холбооны (IDSF) Тэмцээний дүрэм ба Олон улсын тэмцээн зохион байгуулдаг практикаас үндэслэн боловсруулав